

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийг хүлээн авах ажлын хэсгийн ДҮГНЭЛТ

2022 оны 10 дугаар сарын 16 өдөр

Дугаар: 02

Өвөрхангай аймаг

“ӨГӨӨМӨР-ӨРГӨӨ” ХХКОМПАНИЙН ЗАХИРАЛ С.ДОРЖДАВГАД

Байгаль орчны менежментийн
төлөвлөгөөний хэрэгжилтийн
тухай

1. Төсөл хэрэгжүүлэгч ААН-ийн нэр: “Өгөөмөр-Өргөө” ХХК, РД:2681404
2. Төслийн байршил: Өвөрхангай аймаг, Уянга сум, 7-р баг, Мод мухар
3. Тусгай зөвшөөрлийн дугаар: MV-007104

“Өгөөмөр-Өргөө” ХХКомпанийн ирүүлсэн хүсэлтийн дагуу Өвөрхангай аймгийн Засаг даргын 2020 оны 05 дугаар сарын 28-ны өдрийн А/245 дугаар захирамжаар байгуулагдсан байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хүлээн авах аймаг, сумын ажлын хэсэг Уянга сумын Мод мухарын MV-007104 дугаар тусгай зөвшөөрөл бүхий алтны шороон ордын 2022 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийг 2022 оны 10 дугаар сарын 18-ны өдөр “Өгөөмөр-Өргөө” ХХКомпанийн холбогдох албан тушаалтнуудыг байлцуулан шалгалаа.

Тус компанийн тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний бүрэлдэхүүн хэсэг тус бүрд ажлын хэсгийн гишүүд үнэлгээ өгч, гишүүдийн өгсөн үнэлгээг нэмж, арифметик дунджийг гаргалаа. (Хүснэгт)

№	Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний бүрэлдэхүүн хэсгүүд	Авсан байвал зохих оноо	Гишүүдийн үнэлсэн онооны энгийн арифметик дундаж оноо	Үндэслэл тайлбар
1	Техникийн нөхөн сэргээлт хийх төлөвлөгөөний биелэлт	45	39.6	Төлөвлөгөө: Техник- 4.9 га Биологи- 3 га Биелэлт: Техник- 4.5 га Биологи- 3 га
2	Биологийн нөхөн сэргээлт хийх төлөвлөгөөний биелэлт			
3	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт	20	18.3	
4	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлт	10	9	
5	Дүйцүүлэн хамгааллын арга хэмжээний төлөвлөгөөний	10	10	Гар аргаар ашигт малтмал олборлогч

	биелэлт			иргэдийн үйл ажиллагааны улмаас эвдрэлд орж, нөхөн сэргээгдээгүй орхигдсан 3 га талбайд нөхөн сэргээлт хийхээр гэрээ байгуулсан
6	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт	5	4.8	
7	Химийн бодисын эрсдлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт	0	0	Арга хэмжээ төлөвлөгдөөгүй
8	Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт	5	5	
9	Олон нийтэд тайлагнах хуваарь, төлөвлөгөөний биелэлт	5	4.5	
10	Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт	0	0	Арга хэмжээ төлөвлөгдөөгүй
11	Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт	0	0	Арга хэмжээ төлөвлөгдөөгүй
	Нийт	100	91.2	

Дээрх үнэлгээг үндэслэн ДҮГНЭЛТ болгох нь:

1. “Өгөөмөр-Өргөө”ХХКомпанийн MV-007104 дугаартай тусгай зөвшөөрлийн талбайн 4.5 га талбайд хийсэн техникийн нөхөн сэргээлт нь “Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар эвдэгдсэн газрын нөхөн сэргээлт. Техникийн ерөнхий шаардлага MNS 5917:2008” стандартын ерөнхий шаардлагыг, 3 га талбайд хийж гүйцэтгэсэн биологийн нөхөн сэргээлтийн ажил нь “Эвдэрсэн газрын ургамалжуулах. Техникийн ерөнхий шаардлага MNS 5918:2008” стандартын шаардлагыг тус тус хангаж байна

2. Мод мухарын MV-007104 дугаар тусгай зөвшөөрөл бүхий алтны шороон ордын 2022 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийг бүрэлдэхүүн хэсэг тус бүрээр дүгнэхэд 91.2 %-ийн хэрэгжилттэй дүгнэгдлээ.

Иймд байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг сайжруулах, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар дараах зөвлөмжийг хавсралтаар хүргүүлээ.

ДҮГНЭЛТ ГАРГАСАН:

Ажлын хэсгийн ахлагч:

БОАЖГазрын дарга

Нарийн бичиг: БОАЖГазрын мэргэжилтэн

Гишүүд:

ЦГазрын экологийн асуудал хариуцсан эрүүгийн



Г.Баясгалан

Ц.Болдбаатар

ахлах мөрдөгч, Ц/хошууч	А.Батзул
МХГазрын ГУУХУБайцаагч	Т.Өчирсүрэн
МХГазрын БОХУБайцаагч	Б.Бумбанямбуу
Онги-Таац ГСГЗахиргааны мэргэжилтэн	Ц.Дамдинсүрэн
Онги-Таац ГСГЗахиргааны мэргэжилтэн	Б.Даваацэрэн
Уянга сумын Засаг даргын орлогч	Т.Болдбаатар
Уянга сумын БОХУБайцаагч	Д.Санжидмаа
Уянга сумын байгаль хамгаалагч	Х.Дашренчин
Уянга сумын 7-р багийн Засаг дарга	Б.Тамсаг
Уянга сумын 6-р багийн Засаг дарга	Ц.Даваа

ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРСӨН:

“Өгөөмөр-Өргөө” ХХК-ийн захирал

С.Дорждавга



-oOo-

**Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийг хүлээн
авах ажлын хэсгийн ЗӨВЛӨМЖ**

2022 оны 10 дугаар сарын 10 өдөр

Дугаар: 2

Өвөрхангай аймаг

**“ӨГӨӨМӨР-ӨРГӨӨ” ХХКОМПАНИЙН ЗАХИРАЛ
С.ДОРЖДАВГА-Д**

**Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний
хэрэгжилтийн тухай**

“Өгөөмөр-Өргөө” ХХКомпанийн 2022 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг шалгаад дараах зөвлөмжийг хүргүүлж байна.

1. Тухайн жилийн БОМТөлөвлөгөөнд нөхөн сэргээлт хийх талбайн хэмжээ, байршил, солбицолыг тодорхой тусган нөхөн сэргээлтийг холбогдох стандартын дагуу хийх;

2. Урьд онд техникийн нөхөн сэргээлт хийсэн газарт дараа жил биологийн нөхөн сэргээлтийг хийх;

3. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт туссан арга хэмжээг хэрэгжүүлэх хугацаа, газрын байршил, солбицолыг төлөвлөгөөнд тодорхой тусгах;

4. Төлөвлөгөөнд орсон ажлуудыг хийх явцдаа фото зургаар баримтжуулж, тайланд хавсаргах;

5. Тухайн жилийн БОМТөлөвлөгөөг боловсруулахдаа орон нутгийн холбогдох газраас санал авч төлөвлөгөөнд тусгах;

6. Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 101 дүгээр зүйлд заасны дагуу байгаль орчны аудитыг 2 жил тутамд хийлгэж, зөвлөмжийн хэрэгжилтийг ханган ажиллах;

7. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4.6, 9 дүгээр зүйлийн 9.6 дахь заалт, Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний журам болон тухайн жилийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд туссан дүйцүүлэн хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлэх зорилгоор гар аргаар ашигт малтмал олборлогч иргэдийн үйл ажиллагааны улмаас эвдрэлд орж нөхөн сэргээгдээгүй орхигдсон газарт 2023 оны 2 дугаар улиралд нөхөн сэргээлтийн ажлыг холбогдох стандартын дагуу хийж, газрыг цаашид бэлчээрийн зориулалтаар ашиглах нөхцөлийг бүрдүүлж, орон нутагт хүлээлгэн өгөх;

ЗӨВЛӨМЖ ГАРГАСАН:

Ажлын хэсгийн ахлагч:

БОАЖГазрын дарга

Нарийн бичиг: БОАЖГазрын мэргэжилтэн

Гишүүд:

ЦГазрын экологийн асуудал хариуцсан эрүүгийн

ахлах мөрдөгч, Ц/хошууч



Г.Баясгалан

Ц.Болдбаатар

А.Батзул

МХГазрын ГУУХУБайцаагч

МХГазрын БОХУБайцаагч

Онги-Таац ГСГЗахиргааны мэргэжилтэн

Онги-Таац ГСГЗахиргааны мэргэжилтэн

Уянга сумын Засаг даргын орлогч

Уянга сумын БОХУБайцаагч

Уянга сумын байгаль хамгаалагч

Уянга сумын 7-р багийн Засаг дарга

Уянга сумын 6-р багийн Засаг дарга

Б.Очирсүрэн

Б.Бумбанямбуу

Ц.Дамдинсүрэн

Б.Даваацэрэн

Д.Болдбаатар

Д.Санжидмаа

Х.Дашренчин

Б.Тамсаг

Ц.Даваа



-oOo-

**НӨХӨН СЭРГЭЭЛТ ХИЙСЭН ГАЗРЫГ ХҮЛЭЭН
АВСАН ТУХАЙ АКТ**

№ *ах*

2022 оны *10* дүгээр сарын *16*-ний өдөр

Өвөрхангай аймаг

№	Асуулт	Хариулт
1	Байршил: Аймаг, нийслэл: сум, дүүрэг: баг хороо: газрын нэр	Өвөрхангай, Уянга сум, 7 баг, Мод мухар
2	Аж ахуй нэгжийн нэр хаяг: Аж ахуй нэгжийн гэрчилгээний дугаар: Регистер:	“Өгөөмөр-Өргөө” ХХК, Өвөрхангай аймаг, Арвайхээр сум, 1-р баг, Сумдын төв, өөрийн байр 1011001090 2681404
3	Ашиглалтын тусгай зөвшөөрлийн дугаар: Талбай:	MV-007104 184.10 га
4	Нөхөн сэргээлт хүлээлгэн өгсөн албан тушаалтан: Овог нэр:	“Өгөөмөр-Өргөө” ХХК Захирал С.Дорждавга
5	Нөхөн сэргээлтийн ажлыг газар дээр нь хэмжиж зураглал үйлдсэн мэргэжлийн байгууллагын нэр: Хаяг	-
6	Нөхөн сэргээлтийн ажлын хэмжээ, чанар, үр дүн:	Нөхөн сэргээлтийн ажлын хэмжээ, чанар, үр дүн: Тус компани нь уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдрэлд орсон 4.5 га талбайд техникийн нөхөн сэргээлтийн ажлыг хийж, тухайн газрыг анхны төлөв байдалд ойртуулан тэгшилсэн бөгөөд гадаргуугын налуу 18°-аас бага, хажуугийн налуу 25° -аас бага байсан болно. Биологийн нөхөн сэргээлтэд ерхөг, дагуур өлөнт, ботууль, согоовор, хүцэнгэ зэрэг 5 төрлийн ургамал тариалан 3 га талбайг ургамалжуулан хашаалсан байна
7	Нөхөн сэргээлт хийсэн газрын хэмжээ: <u>Нэг. Техникийн нөхөн сэргээлт</u> Талбайн хэмжээ /га-аар/ Хийсэн ажлын хэмжээ /м³ ээр/ Зардал /төгрөгөөр/ <u>Хоёр. Биологийн нөхөн сэргээлт</u> Талбайн хэмжээ /га-аар/ Хийсэн ажлын хэмжээ /м³ ээр/ Зардал /төгрөгөөр/	Техникийн нөхөн сэргээлт 4.5 га 40.500 м³ 18.000.00 төгрөг Биологийн нөхөн сэргээлт 3 га 6.000 м³ 30.500.000 төгрөг

8	Нэмэлт мэдээлэл	<i>Нөхөн сэргээлт хийсэн газрын солбицол</i>		
		№	Өргөрөг	Уртраг
		Техникийн нөхөн сэргээлт		
		1	46° 35' 28.500" N	102° 16' 33.390" E
		2	46° 35' 29.490" N	102° 16' 24.590" E
		3	46° 35' 29.520" N	102° 16' 17.490" E
		4	46° 35' 32.950" N	102° 16' 17.550" E
		5	46° 35' 32.540" N	102° 16' 23.360" E
		6	46° 35' 31.300" N	102° 16' 32.490" E
		7	46° 35' 30.830" N	102° 16' 35.900" E
		8	46° 35' 29.410" N	102° 16' 35.920" E
		Биологийн нөхөн сэргээлт		
		1	46° 35' 40.990" N	102° 16' 49.020" E
		2	46° 35' 44.660" N	102° 16' 45.360" E
		3	46° 35' 46.561" N	102° 16' 50.004" E
		4	46° 35' 44.600" N	102° 16' 52.700" E
		5	46° 35' 42.840" N	102° 16' 53.300" E
		Биологийн нөхөн сэргээлт		
		1	46° 35' 44.660" N	102° 16' 45.360" E
		2	46° 35' 51.350" N	102° 16' 37.730" E
3	46° 35' 52.900" N	102° 16' 41.370" E		
4	46° 35' 46.920" N	102° 16' 50.270" E		
5	46° 35' 46.561" N	102° 16' 50.004" E		

Нөхөн сэргээлт хийсэн тухай:

ДҮГНЭЛТ: “Өгөөмөр-Өргөө”ХХКомпанийн MV-007104 дугаартай тусгай зөвшөөрлийн талбайн 4.5 га талбайд хийсэн техникийн нөхөн сэргээлт нь “Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар эвдэгдсэн газрын нөхөн сэргээлт. Техникийн ерөнхий шаардлага MNS 5917:2008” стандартын ерөнхий шаардлагыг, 3 га талбайд хийж гүйцэтгэсэн биологийн нөхөн сэргээлтийн ажил нь “Эвдэрсэн газрын ургамалжуулах. Техникийн ерөнхий шаардлага MNS 5918:2008” стандартын шаардлагыг тус тус хангаж байна

АКТ ГАРГАСАН:

Ажлын хэсгийн ахлагч:

БОАЖГазрын дарга

Нарийн бичиг: БОАЖГазрын мэргэжилтэн

Гишүүд:

ЦГазрын экологийн асуудал хариуцсан эрүүгийн

ахлах мөрдөгч, Ц/хошууч

МХГазрын ГУУХУБайцаагч

МХГазрын БОХУБайцаагч

Онги-Таац ГСГЗахиргааны мэргэжилтэн

Онги-Таац ГСГЗахиргааны мэргэжилтэн

Г.Баясгалан

Ц.Болдбаатар

А.Батзул

Т.Очирсүрэн

Б.Бумбанямбуу

Ц.Дамдинсүрэн

Б.Даваацэрэн

Уянга сумын Засаг даргын орлогч

T. Болд



Болдбаатар

Уянга сумын БОХУБайцаагч

Д.Санжидмаа

Уянга сумын байгаль хамгаалагч

Х.Дашренчин

Уянга сумын 7-р багийн Засаг дарга

Б.Тамсаг

Уянга сумын 6-р багийн Засаг дарга

Ц.Даваа *Дэв*

ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРСӨН:

"Өгөөмөр-Өргөө" ХХК-ийн захирал



С.Дорждавга

-oOo-

ТТТ2739.т. 2681404

ӨГӨӨМӨР ӨРГӨӨ ХХК-НЫ 2022 ОНЫ НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ЗУРАГ /МУ-007104А/

Ажлын хэсэг

Ажлын хэсгийн ахлагч:
БОАЖГазрын дарга Г.Баясгалан

Нарийн бичиг:
БОАЖГазрын мэргэжилтэн Ц.Болдбаатар

Гишүүд:
Аймгийн ЦГазрын ЭАХ ахлагч мөрдөгч, хошууч А.Батзул
МХГ-ын ГУУХУ байцаагч Т.Очирсүрэн
МХГ-ын БОХУ байцаагч Б.Бумбаянмоу
Онги-Тааз голын ГСГЗахиргааны мэргэжилтэн Ц.Дамдинсүрэн
Онги-Тааз голын ГСГЗахиргааны мэргэжилтэн Б.Даваацэрэн
Уянга сумын Засаг даргын орлогч Г.Болдбаатар
Уянга сумын БОХУБайцаагч Д.Сандаидмаа
Уянга сумын Байгаль хамгаалагч Х.Дашренчин
Уянга сумын 7-р багийн Засаг дарга Б.Тамсаг
Уянга сумын 6-р багийн Засаг дарга Ц.Даваацэрэн.

Хүлээн зөвшөөрсөн:
"Өгөөмөр өргөө" ХХК ны захирал Д.С.Дорждавга



2022 онд хийсэн техник, биологийн нөхөн сэргээлтний координат

Биологийн нөхөн сэргээлт






№	метрийн		уртраг			өргөрөг		
	X	Y	град	мин	сек	град	мин	сек
1	291449	5164050	102	16	37.73	46	35	51.35
2	291528	5164095	102	16	41.37	46	35	52.90
3	291711	5163904	102	16	50.27	46	35	46.92
4	291604	5163838	102	16	45.36	46	35	44.66
5	291449	5164050	102	16	37.73	46	35	51.35

Техникийн нөхөн сэргээлт №2


№	метрийн		уртраг			өргөрөг		
	X	Y	град	мин	сек	град	мин	сек
1	291711	5163904	102	16	50.27	46	35	46.92
2	291761	5163846	102	16	52.71	46	35	45.10
3	291742	5163833	102	16	51.84	46	35	44.66
4	291771	5163776	102	16	53.30	46	35	42.84
5	291678	5163722	102	16	49.02	46	35	40.99
6	291604	5163838	102	16	45.36	46	35	44.66
7	291711	5163904	102	16	50.27	46	35	46.92

Техникийн нөхөн сэргээлт /баруун жалга/

№	метрийн		уртраг			өргөрөг		
	X	Y	град	мин	сек	град	мин	сек
1	291000	5163497	102	16	17.55	46	35	32.95
2	291123	5163480	102	16	23.36	46	35	32.54
3	291316	5163435	102	16	32.49	46	35	31.30
4	291388	5163418	102	16	35.90	46	35	30.83
5	291387	5163374	102	16	35.92	46	35	29.41
6	291331	5163348	102	16	33.39	46	35	28.50
7	291146	5163385	102	16	24.59	46	35	29.49
8	290995	5163391	102	16	17.49	46	35	29.52
9	291000	5163497	102	16	17.55	46	35	32.95

-  Тусгай зөвшөөрлийн хил
-  2017-2020 оны биологийн нөхөн сэргээлт
-  2022 оны мод тариалсан талбай
-  2022 оны биологийн нөхөн сэргээлт
-  2022 оны техникийн нөхөн сэргээлт

Бичил болон нинжа нарт өмнө өртсөн талбай





Агуулга

1.	ТОВЧ ТАНИЛЦУУЛГА.....	1
1.1	Захиргааны харьяалал.....	1
1.2	Төслийн түүхэн товчоо.....	4
1.3	геологийн тогтоц.....	4
1.4	БОННУ-ний тайлан.....	4
1.5	Уур амьсгалын тухай товч мэдээлэл.....	5
2.	БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗОРИЛГО.....	5
3.	СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ.....	6
3.1	Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөлөл.....	6
3.2	Хөрсөн бүрхэвчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл.....	7-15
3.3	Усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл.....	16-17
3.4	Биологийн олон янз байдалд сөрөг нөлөөллийг бууруулах үйл ажиллагаа.....	18-19
4.	НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ.....	19
	Тайлант онд хийж гүйцэтгэхээр төлөвлөсөн ажлууд.....	19
4.1	Техникийн нөхөн сэргээлт.....	20-24
4.2	Биологийн нөхөн сэргээлт.....	24-29
4.3	Мод тариалалт.....	30-32
4.4	Шимт хөрсний нөөц бүрдүүлэн хамгаалах.....	33
5.	ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ.....	34
6.	ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ.....	34
7.	ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ.....	34-36
8.	ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ.....	37
9.	ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР.....	38
10.	ОЛОН НИЙТИЙН ОРОЛЦООГ ХАНГАХ.....	38
11.	УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ.....	38
12.	ТАЛУУДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ.....	39
13.	БОМТ-НИЙ ЗАРДАЛ.....	39
14.	ОРОН НУТГИЙН ХАМТЫН АЖИЛЛАГАА.....	40
15.	ХАВСРАЛТ МАТЕРИАЛ ЖАГСААЛТ.....	41



1. ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

“АУМ” ХХК нь Өвөрхангай аймгийн Уянга сумын нутагт орших Мод мухар нэртэй MV-007104 дугаартай тусгай зөвшөөрөл бүхий ордыг 2007 оны 11 сард “Эрэл” ХХК-аас авсан байна.


Харин “Өгөөмөр-Өргөө” ХХК нь 184.10 га талбай, MV-007104 дугаартай тусгай зөвшөөрөл бүхий ордыг 2019 онд “АУМ” ХХК-аас авсан бөгөөд тус ашиглалтын тусгай зөвшөөрлийг үндэслэн алтны шороон ордын тодотгол хайгуулын ажлыг 2017 оны 05-р сарын 1-ээс 2017 оны 10-р сарын 20-ны дотор өөрийн хөрөнгөөр хийж гүйцэтгэсэн байна.

Уг “Мод мухар” нэртэй MV-007104 тоот тусгай зөвшөөрлийн талбайн нөөцийг анх ЭБМЗ-ийн 2010 оны 06-р сарын 04-ны өдрийн хурлын ХХ-07-08 тоот дүгнэлтийг үндэслэн гаргасан АМГ-ын даргын 2010 оны 06-р сарын 23-ны өдрийн 255 дугаар тушаалаар ордын нөөцийг бодитой В зэргээр 138.5 мян.м³ элс, алтны нөөцийг хими цэврээр 146.25 кг, ордын дунджаар 1056 мг/м³ агуулгатайгаар хүлээн авч ашигт малтмалын нөөцийн улсын нэгдсэн тоо бүртгэлд бүртгүүлсэн байна.

“Өгөөмөр-Өргөө” ХХК нь 2017 онд нарийвчилсан хайгуул хийж нөөцийн тодотголыг ЭБМЗ-өөр хэлэлцүүлэн ЭБМЗ-ийн 2018 оны 07 дугаар сарын 09-ны өдрийн Н/99 дүгээр тушаалаар ордын нөөцийг бодитой В зэргээр 54.22 мян.м³ элс, алтны нөөцийг хими цэврээр 40.45 кг, ордын дунджаар 857.39 мг/м³ агуулгатайгаар хүлээн авч ашигт малтмалын нөөцийн улсын нэгдсэн тоо бүртгэлд нэмж бүртгүүлсэн байна.

1.1. Засаг захиргааны харьяалал

“Өгөөмөр өргөө” ХХК-ийн эзэмшил дэх MV-007104 ашиглалтын тусгай зөвшөөрлийн дугаартай 184.1 гектар талбай нь Өвөрхангай аймгийн Уянга сумаас зүүн хойш 18км, Өвөрхангай аймгийн төв Арвайхээр хотоос баруун хойш 61км, Улаанбаатар хотоос 492км зайд оршдог.



Зураг № 1. Мод мухарын лицензийн талбайн байршлийн зураг

Хүснэгт № 1. Компанийн мэдээлэл

№	Үзүүлэлтүүд	Тайлбар
1	Аж ахуйн нэгжийн нэр	“Өгөөмөр-Өргөө” ХХК
2	Улсын бүртгэлийн дугаар	1011001090
3	Регистрийн дугаар	2681404
4	Аж ахуйн нэгжийн хаяг	Өвөрхангай аймаг, Арвайхээр, 1-р баг, Сумын төвд-Өөрийн байранд Утас: 99096995,91957511
5	Тусгай зөвшөөрлийн дугаар	MV-007104
6	Талбайн хэмжээ, га	184.10
7	Талбайн байршил	Өвөрхангай аймаг, Уянга сум, Мод мухарын ам
8	Төслийн зорилго	Өвөрхангай аймгийн Уянга сумын нутагт орших Мод мухар нэртэй алтны шороон ордыг эдийн засгийн үр ашигтайгаар ашиглах, Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй холбогдох хууль, дүрэм журам, стандартын дагуу үйл ажиллагаагаа явуулж, улс орон нутагт татвар төлбөрүүдийг төлөх, хүрээлэн буй орчинд сөрөг нөлөөлөл багатайгаар олборлолт ашиглалт явуулах, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлт хийх, шинээр 34 хүний ажлын байр бий болгох, ордын үр ашгийг улс, орон нутаг болон төсөл хэрэгжүүлэгч компанид хүртээхэд уг төслийн зорилго оршино.



1.2. Төслийн түүхэн товчоо

Төсөл эхэлсэн огноо “Өгөөмөр өргөө” ХХК нь Өвөрхангай аймгийн Уянга сумаас хойд зүгт 18км зайд орших Мод мухарын ам нэртэй 7104А дугаартай тусгай зөвшөөрөл бүхий ордыг 2016 оны 8 сард “АУМ” ХХК-аас авсан байна. “Өгөөмөр өргөө” ХХК-нь 2016-2018 онд үйл ажиллагаа явуулж, нөөцийн хасалтыг тухай бүрт нь хийлгэсэн байна.

Төслийн техник эдийн засгийн үндэслэл: Мод мухарын шиглах техник эдийн засгийн үндэслэл (ТЭЗҮ)-г Ашигт малтмалын газрын Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөр 2019 оны 06-р сарын 20-ны өдөр хэлэлцэж № Т/19-10-11 тоот дүгнэлтийг гаргасан. Энэ дүгнэлтэнд үндэслэн Ашигт малтмал, газрын тосны газрын даргын 2019 оны 09-р сарын 27-ны өдрийн Т/169 тоот тушаалаар Мод мухар ордыг ашиглах ТЭЗҮ-г хүлээн авсан.

2022 оны төлөвлөлийн нийт бүтээгдэхүүний хэмжээ: 2022 онд Мод мухар ордын 4-В-3,14-В-4хэсгүүдэд уулын ажлыг явуулахаар төлөвлөөд байна. 18.22мян.м3 элс олборлож 117.08 мян.м3 хөрс хуулагдах ба 9.19 кг металл олборлож борлуулахаар ажилласан.

Ордын геологийн тогтоц

Эрэл-хайгуулын ажлаар шийдэж, ашиглалт хийхээр нөөц өгөгдөж буй Мод мухарын амны алтны шижирмэг орд орчмын геологийн тогтцыг, 1990-1992 онд хийсэн 1:50000-ы масштабын геологийн эрэл-зураглалын ажлаар зохиогдсон 1:25000-ны масштабын 122км² талбайг хамарсан геологи-литологийн зурагт үзүүллээ. Энэ талбайд тус орд газар орчмын геологийн биетүүдийн бүтэц, орд үүссэн хүчин зүйлийг илэрхийлж чадах буюу алтны үндсэн болон шижирмэг орд илрэл бүрэлдэх геологи, морфологийн ба бусад хүдэржилт явагдсан шалгуур тусгагдсан хэсэг гэж үзэв. Энэ хэсэгт 1950-иад оноос эхлэн 1980 -аад онуудад жижиг, дунд масштабын геологийн зураглалын судалгаа, тухайлбал Т.Семейхан нар (1968), Д.Тогтох нар (1986) 1:50000-ын масштабын геологийн зураглалын ажил хийж, геологи ашигт малтмалын бүтэц, тархалтын талаар цэгцтэй мэдээллийг өгч, Б.Уртнасан нар (1968) Өлтийн ам, Хуурай сайр (Тарагт суманд)-ын хэсэгт шалгалтын ажил гүйцэтгэн, тэр хэсгүүдийн геологийн бүдүүвч зургийг 1:50000-ын масштабтай зохиож алтны илрэлд цаашид нарийвчилсан судалгаа хийх шаардлагатай гэсэн нь 1990-1992 онд судалгаа хийх ажлын үндэслэл болжээ. Судалгааны дүнд Мод мухарын амны геологийн бүрдлүүд, ашигт малтмалын орд, илрэлийг ялган тогтоож шижирмэг /асгарага/ ордуудын нөөцийн үнэлгээг өгчээ.

1.3 БОННУ-ний тайлан

Байгаль орчин, Аялал жуулчлалын яамны 2019 оны 11 дүгээр сарын 06-ны өдрийн 13/7826 тоот бичгээр “Өгөөмөр-Өргөө” ХХК-д өгсөн Ерөнхий шинжээчийн “Байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээний дүгнэлт”-ээр MV-007104 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй “Мод мухар” нэртэй алтны шороон ордын төсөлд Байгаль Орчин, Ногоон Хөгжлийн Сайдын 2014 оны 04 сарын 10-ны өдрийн



А-117 дугаар тушаалаар батлагдсан “Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийх аргачлал”-ын дагуу байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийлгэх шаардлагатай гэж шийдвэрлэсэн байна.

Хүснэгт № 2. БОННУ-ний тайлангийн мэдээлэл

№	Уурхай	Байгаль орчны ерөнхий үнэлгээ	Байгаль орчны нарийвчилсан үнэлгээ
1	Мод мухар	2019/11/06 №13/7826	2019, Их зос ХХК

Мод мухарын уурхайд хамаарах алтны шороон орд олборлохтой холбоотой үйл ажиллагааны сөрөг нөлөөллийг хууль эрх зүйн шаардлагын дагуу багасгах, арилгах арга хэмжээ, шаардлагатай судалгаа шинжилгээ, нөхөн сэргээлтийн бэлтгэлийг төлөвлөж хэрэгжилтийг тайлагнах бичиг баримт болно.

Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд уурхай тус бүрийн Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний тайланд туссан болзошгүй болон, сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээг хуулийн дагуу хэрэгжүүлж ажиллаж байна. Манай компани нь ашиглалтын үйл ажиллагаа явагдаж байгаатай холбогдуулан байгаль орчны удирдлагын зохистой менежментийг бий болгон жил бүр сайжруулах зорилго тавин ажиллаж байна.

1.4 Уур амьсгалын тухай товч мэдээлэл

Агаарын температурын дундаж хэм нь нэгдүгээр сард -18.1°C , хамгийн хүйтэн нь -44 хэм хүрдэг. Жилийн хамгийн дулаан сар 7-р сар бөгөөд агаарын дундаж температур $20-25$ хэм дулаан байдаг. Агаарын хоногийн дундаж температур $+10^{\circ}\text{C}$ ба түүнээс дээш байх өдрийн тоо $120-130$ хоног, 30°C -аас ба түүнээс дээш температуртай өдрийн тоо $20-30$, 7-р сарын агаарын үнмлэхүй их температур 30°C , -30°C ба түүнээс хүйтэн температуртай өдрийн тоо $40-50$, нэгдүгээр сарын агаарын үнэмлэхүй бага температурын дундаж -34°C байна. Жилийн нар гийгүүлэх хугацаа өвлийн нэг өдөрт 6 цаг, зуны нэг өдөр 10 цаг, жилийн хугацаанд $3000-3200$ цаг байна.

2. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗОРИЛГО

2022 байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь Мод мухарын алтны шороон орд газрын ил уурхайн үйл ажиллагааны явцад байгаль орчны чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлох зорилготой. Өгөөмөр өргөө ХХК нь ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн хувьд уурхайлалтын үйл ажиллагаанд тус байгаль орчны менежментийн төлөвлөгөөгөөр дараах арга хэмжээг хэрэгжүүлэхийг зорьсон. Үүнд:

- Уурхайн үйл ажиллагаанд хамрагдаж байгаа талбайн хэмжээнд байгаль орчны хуулийн нийцлийг хангах,
- БОННУнэлгээний заалтуудыг хэрэгжүүлэх,
- Өгөөмөр өргөө ХХК-ийн байгаль орчны бодлогыг хэрэгжүүлэх,
- Байгаль орчны төлөвлөгөөг хэрэгжүүлэх хамаарал, хамрах хүрээг тодорхойлох,
- Талуудын оролцоог хангах, олон нийтийн оролцоог хамруулах, тайлагнах тогтолцоог сайжруулах.



3. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

3.1. Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөлөл

№	Арга хэмжээ	Хэрэгжилтийн товч тодорхойлолт
1	Агаары чанарын шинжилгээ хийлгэх	Өвөрхангай аймаг дахь УЦУОШ-ны төвийн байгаль орчны шинжилгээний лабораторид хийлгэсэн
2	Уурхай, хотхонд тоосжилт бууруулах зүлэгжүүлэлт үүсгэх хамгаалах.	Уурхайн хотхон хашаалж жимсний мод тарьж,явган зам гаргах, зогсоол болон хурдны хязгаарын тэмдэгжүүлсэн.
3	Тоосжилт бууруулах зорилгоор уурхайн дотоод гадаад замын арчилгаа хийх замын арчилгаа хийж тогтсон зам гаргах	Угаан баяжуулах төхөөрөмжийн гааль, шламын тээвэрлэлтийг уурхайн дотоод замд ашиглан тоосжилтыг дарах арга хэрэглсэн ба мөн хайрган гучил хийлт тогтсон нэг маршрут гарган ажилласан

3.1 Агаарын чанарын шинжлэгээ



УС,ЦАГ УУР ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВ
БАЙГАЛЬ ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ
ЛАБОРАТОРИ

Өвөрхангай аймаг Арвайхээр сум 13-р баг
Утас/Факс: 70322472



ИТГЭМЖЛЭГДСЭН ЛАБОРАТОРИЙН СОРИЛТЫН ДҮН

Дугаар он № : 2022/ 23-25
Дээжийг ирүүлсэн газрын нэр хаяг утас : ӨГӨӨМӨР ӨРГӨӨ олгосон: 2022.07-18 нд
Дээжийг авсан хүний нэр албан тушаал : УЦУОШТөв Ш.Оюунбилэг
Дээжийн тоо төрөл : Уурхайн орчны агаарын 3 сорьц
Хүлээн авсан огноо : 2022. 06-р сарын 30нд
Шинжилсэн огноо : 2022.07-р сарын 01нд

№	Сорилт шинжилгээний үзүүлэлтүүд	Сорилтын аргын тэмдэглэгээ	Агаарын чанарын стандарт: MNS 4585:2016	Шинжилгээний дүн			
				Уурхайн орчим	Зам дагуу	Уурхайн кемп	
1	Хүхэрлэг хий мг/м ³	MNS 0017.2.5.12:1988	0,45	0.004	0.003	0.004	
2	азотын давхар исэл мг/м ³	MNS 0017.2.5.11:1988	0,200	0.020	0.010	0.022	
4	Цацрагийн фоны хэмжээ мк/З-цаг	RDS-110	агаар	0.14	0.11	0.13	
			хөрс	0.11	0.10	0.12	
5	Нийт Тоосны агууламж /TSP/, мг/м ³	DustTrak-8530	0,500	дунд аж	0.062	0.045	0.012
				Мин	0.009	0.025	0.010
				Мах	0.195	0.255	0.080

Тайлбар: Агаар дахь Хүхэрлэг хий,Азотын давхар исэл, тоосжилтын агууламж АЧС-аас давсан бохирдолгүй.

Шинжилгээ гүйцэтгэсэн инженер: *[Signature]* Б.Ичинхорлоо

Хянаж баталгаажуулсан

БОШЛабораторийн эрхлэгч: *[Signature]*

Ш.Оюунбилэг



Сорилтын дүн нь зөвхөн шинжилсэн дээжинд хүчинтэй
Хуулбарлан хэрэглэхийг хориглоно



3.2 Мод мухар уурхайн хотхон болон дотоод замуудад тоосжилтын эсрэг авсан арга хэмжээ

Уурхайн хотхон орчимд байгалийн ногоон зүлэгийг хамгаалж хашаалах арга хэмжээ авсан ба мөн нэгдсэн явган зам гаргаж хайрган хучилт хийсэн. Жимсэний мод тариалж хашаалсан болно.



Зураг № 2 Хотхон орчмын байдал 5 сард



Зураг № 3. Хотхон орчмын зүлэгжилт



Зураг № 4



Зураг № 5



Зураг № 4. Хотхон орчмын тоосжилт багасгах жимсний мол тариалж хашаалсан

Уурхайн дотоод технологийн нэг замгүй болон сул шороон зам уурхай хүнд оврын таазын техникийн үүдсэн тоосжилт үүсдэг үүнийг дарах урьдчилан сэргийлэх зорилгоор хайрган хучилт хийх мөн тусгай зориулалтын техник ашиглан нэгдсэн нэг зам гаргаж ажиллах болно.



Автомашины хурдны хязгаарлалт хориглолт

Тоосжилт үүсч болзошгүй газруудад мэдээллэх болон хориглох тэмдэг байршуулах мөн хурдын хязгаарлалт хийж байршуулсан.



Зураг № 5. Тэмдэг тэмдэглэгээ байршуулсан байдал

3.2 Хөрсөн бүрхэвчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл

№	Арга хэмжээ	Хэрэгжилтийн товч тодорхойлолт
1	Тогтсон замын маршрут гаргаж, замыг засаж янзлах хайран хучилт хийх шинэ зам огт гаргахгүй байх.	Тусгай зөвшөөрлийн талбайн хил доторх замаас тоосжилт үүсч хөрсөн бүрхэвч гэмтэх мөн зам талбайгаас хөрс гэмтэх зэргээс хамгаалж хайрган хучилт хийж тогтвортой тогтсон нэг замтай болсон.
2	Эвдрэлд өртсөн зам талбайг хучилт хийх ургамжуулах арга хэмжээ авах	Буд-Ундрам ХХК болон манай 2 ашиглалтын талбай хооронд зайд уурхайн нөлөөгөөс хөрсөн бүрхэвч гэмтсэн хэсэгт 2021 биологийн нөхөн сэргээлт хийж үр цацалт хийсэн ба үргэлжлүүэн арчилж мөн хотхон орчмыг арчлан хамгаалж, баруун жалгнын техник нөхөн сэргээлт мал бэлчээрлэх хэсэгт үр цацалт хийсэн байгаа болно.



2022 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН

3	Асгаралт үүсч хөсрний бохирдол үүсч болзошгүй газруудад урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах /засварын газар, түлш цэнэглэх талбай /	Ахуйн болон аюултай хог хаягдлын сөрөг нөлөөллийг багасгахын тулд үйл ажиллагааны улмаас үүсэж буй хог хаягдлыг ангилан ялгаж зориулалтын талбайд цуглуулсан. Мөн хаягдал тос масло шингэнийг тусгай байгууллагад гэрээгээр тушааж акт үйлдсэн. Түлшийг зориулалтын түгээх машинаар түгээж, засварын талбайг тогтмол хайрган хучилт сэргээж ажиллалаа.
---	--	--



Зураг № 6. Зам арчилгаа хийсэн буй байдал



Зураг №7. Уурхайн хилээс гадна уурхайн нөлөөнд өртсөн талбай сэргээсэн байдал



Асгаралт үүсч болзошгүй газруудад сөрөн нөлөөлөл бууруулах арга хэмжээ

Шатахуун түгээх явцад асгаралт үүсгэх нөхцөл бий болдог тул автомат түгээгүүрээс тусгай зориулалтын түгээх машинаар түгээдэг болно. Мөн ашигласан тос масло нь аюултай аюултай хог хаягдал үүсгэдэг ба аюултай хог хаягдлын бүртгэл хөтлөж тусгай саванд хаягжуулж, зориулалтын хашаанд хадгалж байсан Улаанбаатар хот Сонгино хайрхан дүүрэг 32-р хороо 10-220 тоот байрлах “Эг-Өргөө” ХХК нд 2022 оны 08 сарын 09 ны өдрийн гэрээний манай байгууллын 2022 оны 08 сарын 26ны өдрийн 22/37 тоот



Зураг № 8. Аюултай хог хаягдал тээвэрлсэн байдал



“ЭГ ӨРГӨӨ” ХХК

Монгол улс, Сонгино Хайрхан дүүрэг,
32-р хороо, 10-220 тоот,
Утас: 88110506, 80044141
E-майл: egurquu@mail.com

№ _____
танай _____-ны № _____-т

“ХОГ ХАЯГДАЛ АВАХ ГЭРЭЭ”

2022 оны 08 сарын 09 –ны өдөр

Улаанбаатар хот

Энэхүү гэрээ (цаашид “Гэрээ” гэх)-г нэг талаас “ЭГ ӨРГӨӨ ХХК” (цаашид “Хүлээн авагч” гэх), нөгөө талаас < ӨГӨӨМӨР ӨРГӨӨ ХХК > (цаашид “Нийлүүлэгч” гэх) нар (цаашид хамтад нь “Талууд” гэх) Монгол Улсын Иргэний хууль, хог хаягдлын тухай хуульд заасны дагуу харилцан тохиролцож байгуулав.

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Энэхүү гэрээний зорилго нь Нийлүүлэгч тал нь Хүлээн авагчид ажилсан тос, масло, гидрийн шингэн гэх зэрэг хаягдлыг дахин ашиглах зорилгоор нийлүүлэх, Талуудын эдлэх эрх, хүлээх үүрэг, хариуцлагыг тодорхойлоход оршино.

ХОЁР. ГЭРЭЭНИЙ ГОЛ НӨХЦӨЛ

2.1. Нийлүүлэгч нь дараах хаягдлыг нийлүүлнэ.

№	Нийлүүлэх материал	Хэмжих нэгж: м ³ / м ² / ш (зурах)
1	Бүх төрлийн ажилсан тос,	-
2	Гидрийн шингэн	-

2.2. Талууд бүтэгдэхүүн нийлүүлэх хугацааг дараах байдлаар тохиролцоно.

Нийлүүлэх хугацаа : 2022.08.10-2023.08.10



ГУРАВ. НИЙЛҮҮЛЭГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

3.1. Нийлүүлэгч нь гэрээнд заагдсанаар хаягдал тос, тосолгооны материалыг хүлээн авагчид нийлүүлэх.

ДӨРӨВ. ЗАХИАЛАГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

4.1. Гэрээнд заасан нөхцлөөр ашиглах.
4.2. Хүлээн авагч нь хаягдал тос, тосолгооны материалыг үйлдвэрлэлийн ажиллагаанд ашиглах, байгаль орчинд асгахгүй байх үүрэгтэй.

ТАВ. БУСАД

5.1. Энэхүү гэрээг Хог хягдлын тухай хуулийг удирдлага болгон байгуулсан бөгөөд гэрээг хэрэгжүүлэх, тайлбарлахдаа Хог хягдлын тухай хуулийг хэрэглэнэ.
5.2. Энэхүү гэрээнд талууд харилцан тохиролцсон тохиолдолд нэмэлт өөрчлөлт оруулах бөгөөд нэмэлт, өөрчлөлтийг бичгээр үйлдэж, талуудын эрх бүхий төлөөлөгч гарын үсэг зурж баталгаажуулна.
5.3. Энэхүү гэрээний талууд нь гэрээгээр олгосон эрх, үүргээ нөгөө талын бичгээр олгосон зөвшөөрөлгүйгээр шилжүүлэхийг хориглоно.
5.4. Энэхүү гэрээ хүчин төгөлдөр болсноос хойш гэрээний аль нэг заалт эрх бүхий байгууллагын шийдвэрээр хүчин төгөлдөр буст тооцогдсон нь гэрээний бусад заалтын хүчин төгөлдөр байдалд нөлөөлөхгүй.
5.5. Энэхүү гэрээ нь аливаа гуравдагч этгээдэд эрх, үүрэг, хариуцлага үүсгэхгүй.
5.6. Энэхүү гэрээг Монгол хэл дээр 2 хувь үйлдсэн ба Тал тус бүр нэг хувийг хадгална.
5.7. Энэ гэрээнд Талууд гарын үсэг зурсанаар хүчин төгөлдөр болно.
5.8. Энэхүү гэрээ нь Захиалагч бүтээгдэхүүнээ бүрэн хүлээн авснаар дуусгавар болно.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ

"ӨГӨӨМӨР ӨРГӨӨ" ХХК-ийн Захирал
< С. Дорж-Дорва >

Хаяг: Өв. Арвайхээр сум
Ср/техникийн зах зорин
Утас: 99096995

НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ

"ЭГ ӨРГӨӨ" ХХК-ийн Захиарал
< Д. Баяржаргал >

Хаяг: Улаанбаатар хот Сонгино Хайрхан
Дүүрэг 32-р хороо 10-220 тоот
Утас: 88110506, 80044141



“ӨГӨӨМӨР ӨРГӨӨ” ХХК

202__оны__сарын__өдөр

Дугаар 22/__

Арвайхээр хот

Хаягдал тос масло тээвэрлэх

Манай компани нь Өвөрхангай аймаг Уянга сум дахь МУ-007104 тоот тусгай зөвшөөрөл бүхий Мод мухар уурхайн нэр бүхий бүхий хаягдал тос масло зөөвөрлөн УБ хот дахь СХД, 32-хороо, 10-220 тоот орших “Эг Өргөө” ХХК-нд 2022 /08/09-ны гэрээгээр нийлүүлж байгаа болно.

Харилцах утас: “Эг өргөө” ХХК -80044141

“Өгөөмөр өргөө” ХХК - 91957511

Тоо хэмжээ:

№	Жагсаалт	Хэмжээ
1	масло	660л
2	Тап	60л
3	Тосол	35л
4	Гидро шингэн нийт	315л 1070 литр

ХАБЭАжилтан

Ж.Бямбатогтох

Хаяг: Монгол улс, Өвөрхангай аймаг, Арвайхээр сум, 5-р баг, Орд
техникийн зах, Email: gold_998@yahoo.com. Утас:99096995



“ЭГ ӨРГӨӨ” ХХК.

Монгол улс, Улаанбаатар хот
Сонгино Хайрхан дүүрэг,
32-р хороо, 10-220 тоот,
Утас: 88110506, 80044141
E-майл: egurquu@mail.com

№ _____
танай _____-ны № _____-т

/ӨГӨӨМӨР ӨРГӨӨ ХХК-д/

“Хүлээн авсан акт”

2022оны 8 сарын 29 өдөр

Манай компани 2022 оны 8 сарын 9-нд хийгдсэн гэрээнд заагдсаны дагуу доор дурдсан ажилласан тос, тослох материалыг хүлээн авсан.

№	Жагсаалт	Хэмжээ
1	Моторын тос, Тап, Тосол	1600л
2	Гидро шингэн	800л
	НИЙТ	2400л

Хүлээн авсан:

Үйлдвэрийн дарга:

Захирал:



Handwritten signature in blue ink.

Д.Бат-Эрдэнэ

Д.Баяржаргал

Зураг №9 . Аюултай хог хаягдлын гэрээ болон илгээсэн хүлээн авсан бичиг баримт



3.3 Усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл

№	Арга хэмжээ	Хэрэгжилтийн товч тодорхойлолт
1	Ил уурхайнуудад болон хаягдал чулуулгийн овоолго, уурхайн дотоод зам руу орохоос сэргийлж уурхайн гадаргын үерийн уснаас хамгаалах сан шуудуу байгуулах	Нэмэлт нуур байгуулан мөн үерийн хамгаалалтын шуудуу хийсэн ба улирлын хөлдөлт гэсэлтийн цагт уурхайн ашиглалтын нуур дарагдах эрсдэл үүсэж сэргээн засварлаж хамгаалсан.
2	ШТС болон уурхайн хүнд машин механизм, тээврийн хэрэгслүүдийн хэвийн ажиллагааг хангах, хөрсийг бохирдуулахгүй байх дээр анхаарах	Түлшийг тогтсон нэг цэгээс хангаж, хаягдал тосыг битүү саванд хадгалсан.

3.3.1 Уурхайн үерийн уснаас хамгаалах сан шуудуу хийх




Зураг № 10. Үерийн далан уурхайн зүүн тал кемпий хойд





Хуримтлалын нуурыг

Зураг № 11. Жалауудад ус хуримтал үүсч буй байдал



Зураг № . Худагт байшуулсан тоолуур



Худгийн дугаар	Тоолуурын марк, сери	Худгийн ундраг а, л/сек	Худгийн зориулалт	Баталгаажуулалт гэрчилгээ
				Олгосон огноо
№1	ЭЦВ-6-16-140	-	Үйлдвэрлэл	№1911001958 - 2020/08/19
№2	ЭЦВ-6-10-80	4.0	Уурхай ашиглалт	Тоолуур гэмтсэн

Хүснэгт № 4. 2022 онд төлсөн усны төлбөр

Д/д	Зам талбайн тоосжилт дарах үйлдвэрлэл	Хаягдал ус	Нийт
1	32 366 295		32 366 295
2		637 732.29	637 732.29
3	НИЙТ		33 004 027.29

3.4 Биологийн олон янз байдалд сөрөг нөлөөллийг бууруулах үйл ажиллагаа

№	Арга хэмжээ	Хэрэгжилтийн товч тодорхойлолт
1	Уурхайн эргэн тойронд ан амьтныг хамгаалах	Уурхайн орчимд уурхайн үйл ажиллагаа эхлэснээс хулга анчид үгүй болсоноос уурхай бүсэд тарвагын тоо толгой нүдэнд харагдахуйц өссөн ба 2022 онд 2 удаагийн хууль бус анчидыг хөөн гаргасан болно.
2	Ан, амьтанд биотехникийн арга хэмжээгээр амьд үлдэх, үр төлөө үлдээх нөхцөлийг дэмжих	2021 оны өвөл Өвөрхангай аймгийн Бүрд суманд аймгийн зохих шатны байгууллагуудта хамтран өвс тараах, мөн Уянга суманд санхүүгийн дэмжлэг үзүүлсэн ба 2022 онд ямар нэг ажил хийгдээгүй болно.



3.4.2 Биотехникийн арга хэмжээ



Зураг № 11. Өвс тэжээл тарааж буй байдал

4. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Мод мухар алтны шороон ордын уул-техникийн нөхцөлд тохируулан дотоод овоолготой автотээвэртэй ашиглалтын системийг сонгож ашигласан талбайд



хөрсний дотоод овоолго үүсгэснээр техникийн нөхөн сэргээлтгүйг уулын ажилтай зэрэг явуулах, ногоон байгууламжийн хүрээг нэмэгдүүлэх, МУ-ын хууль болон холбогдох тушаал шийдвэрийг мөрдөн ажиллахаар төлөвлөн хийж гүйцэтгэсэн.

Тайлант онд хийж гүйцэтгэхээр төлөвлөсөн ажлууд

Д/д	Арга хэмжээ	Хэрэгжилтийн тодорхойлолт
1	Карьер болон гадаад овоолгын техникийн нөхөн сэргээлт	2022 онд Уулын ажлын төлөвлөгөөний дагуу олборлотонд өртсөн газарт техникийн нөхөн сэргээлт гүйцэтгэж мөн гадаад овоолго үүсч буй дараа дараагийн онуудад техник болон биологийн нөхөн сэргээлт тусгагдах газруудад тэгшиглэгээний ажлууд хийгдсэн манай уурхайн ашиглалтанд өртөөгүй өмнөх эзэмшигчийн нар хөндөгдсөн баруун жалгы хэсэгт хэобэржүүлэн дарч техникийн нөхөн сэргээлт хийсэн
2	Биологийн нөхөн сэргээлт ба шимт хөрсний овоолго арчилгаа	Тус онд БОМТ-нд тусгагдсан газруудаас гадна нэмж тодорхой хэмжээний газрууд биологийн нөхөн сэргээлт хийсэн. Мөн дараа дараагийн онуудад биологийн нөхөн сэргээлт хэрэглэгдэх үржил шимт хөрсний үржил шимийг хадгалах зорилгоор нэгдсэн нэг овоолго үүсгэсэн

4.1 Техникийн нөхөн сэргээлт





Зураг № 12. Олборлотын ажлын явц

Тус онд уулын ажилд өртсөн 14-В-3, 13-В-7 блокуудад олборлотын ажил гүйцэтгэж 1,9 га талбай хөндөж тус талбайд техникийн нөхөн сэргээлтийн ажил гүйцэтгэсэн болно. Дотоод овоолгын зарчмаар хийсэн ба явцад тэгшилгээний ажлыг экскавотар болон ковш , автогрейдрээр гүйцэтгэсэн.



Зураг № 13. Ашиглалт хийгдсэн талбай техникийн нөхөн сэргээлт

Мөн тус онд уурхайн баруун жалга буюу өмнөх эзэмшигч нар хөндөж олборлолт явуулан орхисон талбайд хэлбэржүүлэн дарж үр цацалт хийсэн болно. Уг талбайд үр цацалт хийсэн хэдий энэ жил хашаалаагүй бөгөөд хашаалсан биологийн нөхөн сэргээлтээс чөлөөтэй байдлаар мал бэлчээрлэдэг ба дараа дараагийн жилд ургалтын байдал үрний хөрсөнд үндэслэх зэргийг туршили болж байгаа болно.



Зураг № 14. Баруун жалга өмнөх байдал





Зураг № 15. Баруун жалга ажлын явц





Зураг № 16. Баруун жалга нөхөн сэргээлтийн дараах байдал

4.2 Биологийн нөхөн сэргээлт

Өвөрхангай аймгийн Засаг даргын захирамжаар гарсан ажлын хэсгийн хүлээн авсан 2021 оны 12 сарын 02-ны өдрийн №03 тоот дүгнэлтээр гарсан 2.79 га техникийн нөхөн сэргээлт бүхий талбайд тус комиссийн зөлөмжийн дагуу урьд онд техникийн нөхөн сэргээлт хийсэн газарт 3.0 га биологийн нөхөн сэргээлт хийсэн болно.

2021 оны БОМТөлөвлөгөөнд энэ 2,79 га талбайд биологийн нөхөн сэргээлт хийгдэхээр төлөвлөсөн ба нийт 3.0 га талбайд биологийн нөхөн сэргээлт хийсэн болно.

Мөн баруун жалганд хөрсний тоосжилт дарах зорилгоор уурхайн эдэлбэр
“Өгөөмөр Өргөө” ХХК



талбайгаас гадна 1.7 га үр цацалт хийсэн.

Нөхөн сэргээлтэнд “Байгалиа дээдэлье” ХХК ны ОХУ-аас оруулж ирсэн

1. Дагуур өлөнт
2. Улаан ботуул
3. Согоовор
4. Нугын ботууль
5. Ерхөг

6. Хүцэнгэ гэх мэт ургамлын үрийг тариалсан ба тус үр нь МХЕГазрын хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лабораториор 2021 оны 05 дугаар сарын 07 ны өдөр шинжилгээнд хамрагдаж баталгаажсан болно.

/ баримт болон үрийн шинжилгээ хавсратаар/



Зураг № 17. Биологийн нөхөн сэргээлт хийсэн талбай өмнө нь 2021/09/13 өдөр





Зураг № 18. Биологийн нөхөн сэргээлт ажлын явц



Зураг № 19. Биологийн нөхөн сэргээлт ургат 06/27



Зураг № 20. Биологийн нөхөн сэргээлт ургат 08/18










Зураг № 19. Нөхөн сэргээлт хийгдсэ талбайг он оноор хаягжуулсан



2021 онд хийсэн техник, биологийн нөхөн сэргээлтийн координат		
Биологийн нөхөн сэргээлт		
№	метрийн	
	X	Y
1	291449	5164050
2	291528	5164095
3	291711	5163904
4	291604	5163838
5	291449	5164050
Техникийн нөхөн сэргээлт №2		
№	метрийн	
	X	Y
1	291711	5163904
2	291761	5163846
3	291742	5163833
4	291771	5163776
5	291678	5163722
6	291604	5163838
7	291711	5163904
Техникийн нөхөн сэргээлт /баруун жалга/		
№	метрийн	
	X	Y
1	291000	5163497
2	291123	5163480
3	291316	5163435
4	291388	5163418
5	291387	5163374
6	291331	5163348
7	291146	5163385
8	290995	5163391
9	291000	5163497



Зураг № 22. 2017-2022 онд хийсэн нийт 14 га биологийн нөхөн сэргээлт

- Таних тэмдэг
-  Мод тарьсан талбай
-  Өмнөх онуудын нөхөн сэргээлт
-  2022 оны биологийн нөхөн сэргээлт
-  2022 оны олборлолтонд өртөж техникийн нөхөн сэргээлт хийсэн талбай

Зураг № 22. 2017-2022 онд хийсэн нийт 14 га биологийн нөхөн сэргээлт



Мод тариалалт: 2022 онд уурхайд 2021 оны биологий нөхөн сэргээлт хийсэн талбайд 1000 ширхэг хайлаас мод тарилсан.

Ургалтын явц 90 хувьтай ургасан ба тариалахдаа үрсэлгээг худалдан авсан байгууллагаас мэргэжлийн арга зүйн зөвөлгөө авч зааварын дагуу тариалсан болно.



Зураг № 23. Бэлдэж байгааг байдал



Зураг № 24 Нүхийг зориулалтын техникээр ухсан



Зураг № 26 Ажлын явц 5/22



6/27



6/22



7/22





4.3 Шимт хөрсний нөөц бүрдүүлэн хамгаалах

Уурхайн ахилт, бүтээн байгуулалт, зам талбай, хөрсний овоолго хийгдэх талбайн шимт хөрсийг хуулж овоолго үүсгэж, стандартын дагуу хамгаалж байна.

2021 онд нийт 13200 мянган м³ шимт хөрс хадгалж байсан ба 2022 оны биологийн нөхөн сэргээлт ашиглалты талбайн өөрийн үржил шимт хөрсөөр хийгдсэн тул тухайн шимт хөрс хэвээр байгаа болно.



Зураг № 25. Мод мухарын уурхайд хадгалж буй шимт хөрс



5. ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

№	Арга хэмжээ	Хэрэгжилтийн товч тодорхойлолт
2	Зэрлэг амьтны мониторинг хийх, биотехникийн арга хэмжээ хэрэгжүүлэх	2021 Өвөрхангай аймагт Бүрд суманд зэрлэг ан амьтанд өвс тэжээл тараах ажилд оролцосон 2022 онд одоогоор ямар нэг ажил хийгдээгүй байгаа болно.
3	Дүйцүүлэн хамгаалах техникийн нөхөн сэргээлт	Өвөрхангай аймгийн засаг даргын дэргэдэх Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Мэргэжилийн хяналтын газар, Цагдаагийн газар, Нарийн тээл сумын засаг дарга, Баруун баян улаан сумын засаг дарга нарын хамтран Уянга суманд үйл ажиллага явуулж буй компаниуд хамтран 2021 онд 16 га талбайд техникийн нөхөн сэргээлт хийх ажилд оролцохоор төлөвлөсөн ч одоогоор хийгдээгүй байгаа бөгөөд цаашид талбай хэмжээ нэмэгдүүлэн манай байгууллагын зүгээс техник, хүн хүчийг татан ороцуулахад бэлэн байгаа болно.

6. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Манай компанийн талбайд болон түүний нөлөөллийн бүсэд өнөөгийн байдлаар ямар нэгэн түүх соёлын дурсгалт зүйл ба археологийн олдвортой газар байхгүй байна. Төслийн хамрах хүрээнд палеонтологийн дурсгал илрээгүй байна. Хэрэв цаашид төслийн хэрэгжилтийн явцад төслийн талбай болон түүний нөлөөллийн бүсэд ямар нэгэн палеонтологийн олдвор олдох үед холбогдох хууль тогтоомжид заасны дагуу засаг захиргааны байгууллага болон холбогдох байгууллага болох ШУА, Палеонтологийн хүрээлэн 70118283, Түүх угсаатны зүйн хүрээлэн 11-458305-д нэн даруй мэдэгдэж арга ажиллах болно.

7. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Арга хэмжээ	Хэрэгжилтийн товч тодорхойлолт
1	ШТС-ын ойролцоо хамгаалалт татах	Уурхайд байрлах ШТС-дын аюулгүй ажиллагааг хангах үүднээс хамгаалалтын шороон хөмсөг болон аюулгүй тууз татаж галаа сараа байруулсан таних тэмдэг хийсн
2	Аянга цахилгаан хур бороон үерийн аюулаас сэргээлэх	Аянга зайлуулалгч шинээр хийж мөн гал аюулгүй байдлын дүгнэлт гаргуулж уурхайн кемпэд галын сараа болон түймэр, үерийн шуудуу татсан



Зураг № 26. ШТС-ад галын сараа болон таних тэмдэн аюулгүй тууз татсан





Онцгой байдалын ерөнхий газрын даргын
2012 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн
29 дүгээр тушаалын 4 дүгээр хавсралт


**АЖЛЫН БАЙРНЫ ГАЛЫН
АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ДҮГНЭЛТ**

Дугаар **01910046**

Аж ахуйн нэгж, байгууллагын нэр: *Өгөөмөр Өргөө ХХК*

Хаяг: *Сваржамтай Уулзга сум 7-р багц*

Ажлын байрны зориулалт, үйл ажиллагааны чиглэл: *Уулзургаас
Аж ахуйн үйлдвэр*

Барилга байгууламжид гал унтраах тоног төхөөрөмж, / гал унтраах автомат болон
дохиоллын систем, утаа зайлуулах систем, усан хангамж /анхан шатны багаж хэрэгсэл,
бодис материал зэргийг байрлуулан ашиглахад энэхүү дүгнэлтийг олгоно.
/Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 33.1.4/
/Галын аюулгүй байдлын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.7/

Олгосон: *2021* он *04* сар *12* өдөр
Хүчинтэй хугацаа: *2023* он *04* сар *12* өдөр хүртэл

Дүгнэлт олгосон: *Сваржамтай* аймаг, нийслэлийн Онцгой байдлын газар /хэлтсийн/
дарга *Сүхбаатар* цолтой *А.Балжинзор*

Дүгнэлт гаргасан: *Сваржамтай* аймаг, нийслэлийн Онцгой байдлын газар /хэлтсийн/
Гал түймрийн улсын хяналтын байцаагч *Ашиг* цолтой *А.Балжинзор*

/гэмдэг дарна/



Зураг № 27. Галын дүгнэлт, аянга газардуулагч, үерийн шуудууны байдал



8. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

№	Арга хэмжээ	Хэрэгжилтийн товч тодорхойлолт
1	Аюултай хог хаягдлын бүртгэлжүүлж хадгалалт тээвэрлэлтэнд тавих хяналтыг сайжруулах	“Аюултай хог хаягдлын бүртгэлжүүлж хадгалалт хамгаалалтыг сайжруулан Улаанбаатар хотруу тээвэрлэн зориулалтын газар тушаан акт үйлдсэн.
2	Бүх нийтийн их цэвэрлэгээг тогтмол хугацаанд зохион байгуулах	Уурхайн орчмыг хогийг цэвэрлэх

Устгалд оруулсан аюултай хог хаягдлын акт



“ЭГ ӨРГӨӨ” ХХК.

Монгол улс, Улаанбаатар хот
Сонгино Хайрхан дүүрэг,
32-р хороо, 10-220 тоот,
Утас: 88110506, 80044141
E-майл: egurquu@mail.com

№ _____
танай _____-ны № _____-т

/ӨГӨӨМӨР ӨРГӨӨ ХХК-д/

“Хүлээн авсан акт”

2022оны 8 сарын 29 өдөр

Манай компани 2022 оны 8 сарын 9-нд хийгдсэн гэрээнд заагдсаны дагуу доор дурдсан ажилласан тос, тослох материалыг хүлээн авсан.

№	Жагсаалт	Хэмжээ
1	Моторын тос, Тап, Тосол	1600л
2	Гидро шингэн	800л
	НИЙТ	2400л

Хүлээн авсан:

Үйлдвэрийн дарга:

Захирал:



Handwritten signature in blue ink.

Д.Бат-Эрдэнэ

Д.Баяржаргал

Зураг № 28. Аюултай хог хаягдалын хамгаалалт хадгалалт



9. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

Өвөрхангай аймгийн УЦУОШЛабораторийн газраар уурхайн нуурын ус, хөрс, агаар мөн гүнийн худгийн шинжилгээг өгч ажилласан.

Нуурын ус 2022 оны 6.7.8 саруудад 3 удаагийн давтамжтай авсан хариугаар Усан орчны MNS 4943:2015 - д үзүүлэлтүүд хэвийн гарсан болно.

Агаарын чанарын шинжилгээ мөн 2022 оны 6 сард авч Агаар дахь Хүхэрлэг Хий, Азотын давхар исэл, Тоосжиты агууламж АЧСаас давсан бохирдолгүй.

Хөрсний агрохимийн шинжилгээ, Хөрсний хүнд металлын болон нефтийн шинжилгээ MNS 3297:2019, MNS5850:2008 үзүүлэлтүүд байх ёстой үзүүлэлтүүд хэвийн байна.

/Шинжилгээний зохих хариуг хавсралтаар/

10. Олон нийтийн оролцоог хангах

Байгаль орчин ногоон хөгжлийн яамны сайдын батласан А-03-р тушаалын Байгаль орчины нөлөөлөх байдлын үнэлгээнд олон нийтийн оролцоог хангах журмын дагуу үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна.

Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн хүрээнд уурхайд хийгддэг байгаль орчны хяналт, шинжилгээ, хэмжилт судалгаанд нутгийн иргэд, оролцогч талуудын төлөөллийг оролцуулах замаар байгаль орчныг хамгаалах чиглэлээр хийж буй үйл ажиллагааг олон нийтэд таниулах, үнэн зөв мэдээллээр хангах зорилготой.

11. УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Удирдлага, зохион байгуулалтыг сайжруулах нь БОМТ–ний хэрэгжилтийн баталгааг бий болгож буй хэлбэр гэж үзэж ихээхэн ач холбогдол өгөх ёстой. БОМТ–ний хэрэгжилтийг хангахад зөвхөн байгаль орчны мэргэжилтэн бус бусад ажилтнууд нарын оролцоо шаардагддаг. Тус дэд төлөвлөгөөгөөр Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтэд оролцооны хэлбэрийг тодорхойлон хэрэгжилтийг хангах зорилтуудыг дэвшүүлэн ажиллаж байна.

11.1 Байгаль орчны хуваарьт аудит хийлгэх

Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1-д Байгалийн нөөц баялаг ашиглан үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлж буй аж ахуйн нэгж, байгууллага бүр хоёр жил тутамд Байгаль орчны аудитыг (БОА) мэргэжлийн байгууллагаар хийлгэх тухай заасны дагуу 2020 онд “МӨНХ МИЗУ КОНСАЛТИНГ”ХХК-иар хийлгэж зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаж хэрэгжилтийн тайланг цахим хэлбэрээр Өвөрхангай аймгийн БОАЖГ-т хүргүүлсэн.



12. ТАЛУУДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Оршин суугч, оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Мэдээний агуулга	Хугацаа	Зохион байгуулах газар	Тайлбар
1	Орон нутгийн удирдлага, ИТХ, БОУБ, Байгаль хамгаалагч	Танилцуулга	БОМТ-ийн хэрэгжилтийн явцыг танилцуулах	10 Сар	Уурхай	Тухай бүрт нь оролцуулж байгаа

13. БОМТ-НИЙ ЗАРДАЛ

Үйл ажиллагааны чиглэл	Төлөвлөсөн төсөв /сая.төг/	Зарцуулсан хөрөнгө /сая.төг/
Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	1.0	2.5
Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	4.2	48.5
Биологийн олон янз байдлын дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	3.5	--*--
Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө	--*--	--*--
Түүх, соёлын өвийг хамгаалах төлөвлөгөө	--*--	--*--
Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	--*--	0.5
Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	0.5	1.2
Орчны хяналт, шинжилгээний хөтөлбөр	0.8	0.8
Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	--*--	--*--
Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний биелэлтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө	--*--	--*--
Мод тариалалт	--*--	22.5
Нийт зардал	10	76.0



14. Орон нутгийн хамтын ажиллагааны биелэлт

Үйл ажиллагаа	Хийгдсэн ажил	Зарцуулсан хөрөнгө /сая.төг/
Шатрын их мастер Гомбосүрэнгийн Мөнхгал	Шагнал, урамшуулал	20
Уянга сумын 90 жилийн ой	хандив	20
Тэр бум мод хөтөлбөрийн хүрээнд Уянга суманд 10000м ² моны хашаа хийх	Нийгмийн хариуцлагын гэрээ	18
Уянга сумаас төрсөн 3 гавъяатад хүндэтгэлийн гэр	Нийгмийн хариуцлагын гэрээ	27.4
Уянга сумын цагдаа, Байгаль орчны байцаагч, Байгаль хамгаалагчид унаа	Нийгмийн хариуцлагын гэрээ	9
	Нийт зардал	94.4



15. ХАВСРАЛТ МАТЕРИАЛ ЖАГСААЛТ

Хавсралт 1. Аж ахуйн нэгжийн гэрчилгээ

Хавсралт 2. Тусгай зөвшөөрлийн гэрчилгээ

Хавсралт 3. Нөөц хүлээн авсан тушаал

Хавсралт 4. ТЭЗҮ хүлээн авсан тушаал

Хавсралт 5. Кадасртын лавлагаа

Хавсралт 7. 2022 он ус, хаягадал ус, хог, барьцаа хөрөнгийн төлбөрийн баримт

Хавсралт 8. Орчны хяналт шинжилгээний бичиг

Хавсралт 9. Хог хаягдлын гэрээ

Хавсралт 10. Ус ашиглалтын дүгнэлт, зөвшөөрөл гэрээ

Хавсралт 11. Хаягдал усны дүгнэлт, зөвшөөрөл